



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар Б/38

Ховд

Б.Цагаанцэцэгийг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, 11.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын туслахын албан тушаалд туршилтын хугацаагаар ажиллаж байгаа Б.Цагаанцэцэгийг 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн аймгийн Засаг даргын туслахаар томилсугай.

2. Б.Цагаанцэцэгийг Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын цалингийн сүлжээний ТҮ-4-1 дэх шатлал болох 485.830 төгрөг /Дөрвөн зуун наян таван мянга найман зуун гучин/-өөр, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу ур чадварын нэмэгдлийг сарын бүрийн үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД